

МОНГОЛЧУУД БА МОНГОЛ ГЭР

А.ГАНЧИМЭГ

Товч агуулга: Сүүлийн жилүүдэд Монгол Улсад монголчуудын соёлын өв, тэр тусмаа нүүдлийн соёлын өвийн талаар улс төр, нийгмийн хүрээнд ихээр яригдаж, тэрхүү өвийг хамгаалан хадгалж, хойч үедээ өвлүүлэн үлдээх талаар янз бүрийн арга хэмжээнүүд авч хэрэгжүүлж байна. Тодруулбал, 2010-2013 оны хооронд орон даяар өрнөсөн соёлын өв, уламжлалт зан үйл, монгол ардын дуу бүжиг г.м. урлагын өвийг хадгалан тээж яваа хүмүүсийг бүртгэх компаниг ажил, мөн 2016 онд засгийн газраас зарласан монголчуудын дуу хөгжим, соёл урлагийг гадаадын улс орнуудад таниж мэдүүлэх зорилготой “Дэлхийн Монголчууд хөтөлбөр”-г нэрлэж болно. Мөн музейн сан хөмрөгийг олон нийтэд таниулахаар 2018 оны гурван сард анх удаа орон даяар зохион байгуулагдсан “Музейн нээлтэй өдрүүд” долоо хоногийн бяс дурдаж болно. Харин эсгий туургатан монголчуудын нүүдлийн аж төрөх ёсноос суурин амьдралд шилжих үе хүртэл амьдрах үндсэн орон сууц нь болсоор ирсэн монгол гэр нь монгол ахуй, ёс зан заншил, урлахуйн ухааны үнэт өвийн нэг юм. Гэтэл өнөөдөр Монгол Улсад монгол гэрийн тухай нийгэмд тархсан ойлголт нь зөвхөн материаллаг эд зүйл утгаар хязгаарлагдан, хоёрхон дүр зургийг илэрхийлж байна. Үүнд нэгдүгээрт: Улаанбаатар хот болон бусад суурин газруудад монгол гэрт буюу гэр хороололд амьдарч буй иргэдийн амьдралын нөхцөл байдалтай холбон байгаль орчин сүйтгэгч, бохир угаа үүсгэгч. Хоёрдугаарт: нүүдэлчин монголчуудын олон зуун жилийн өмнөөс сууж ирсэн нүүж тээвэрлэхэд хялбар орон сууц. Иймд судлаач миний дүгнэлтээр монгол гэрийн тухай нийгэмд тархсан энэхүү хоёрдмол ойлголтын цаадах нарийн учир шалтгааныг задлан үзэх хэрэгтэй. Үүнд эхлээд монголчуудын нүүдлийн соёлын өв гэж юу вэ? Монголчууд ямар учраас монгол гэрийг нүүдлийн соёлын өв хэмээн үздэг вэ? Монголчууд гэж оорсдоо хэн бэ? Монгол Улсын соёлын өв гэж чухам юуг хэлж байна вэ? гэсэн асуултуудад хариулах нь зүйтэй болов уу.

Түлхүүр үг: Соёлын өв, монгол гэр, монгол гэрийн өнөөгийн дүр зураг, монгол гэрийн тухай сөрөг ойлголт

Соёлын өвийн тухай ойлголт

107 жилийн тэртээ Монгол Улс нь Чин улсын эрхнээс гарч, тусгаар тогтнолоо зарласан, 1924 онд БНМАУ-ыг байгуулж, нийгмийн социалист системийг дагнан хөгжих хүртэл улс орон даяар уламжлалт хөөмий, ерөөл, магтаал, тууль хайлдаг, морин хуур, цуур хөгжим тоглодог дуучид, хөгжимчид олон байжээ.¹

¹ 1930 он хүртэл төрөл бүрийн тууль аль бүс нутгуудаар тархан хайлагдаж байсан тухай хэргийн

Харин улс орон социалист хөгжлийн замыг сонгосонтой холбоотойгоор хуучны уламжлалт соёлын зарим зүйлийг, тухайлбал ихэс дээдсийн дунд түгээмэл байсан зарим зүйлийг феодал ёсны хоцрогдсон агаад ард түмнийг мөлжигч нарынх хэмээн ад үзэж үгүйсгэх, нөгөө талаар ажилчин ангийн шинэ соёлыг буй болгоно гэж соёлын хувьд ангийн шинж чанартай бодлого баримталж байв. Энэ байдал нь уламжлалт соёлын зарим зүйл гээгдэхэд хүргэжээ. Ардын дуу, хөгжмийн угсаатны зүй судлаач Pegg-н судалснаар XX-р зууны дунд үеэс эхлэн хувьсгалч үзэл, социалист бүтээн байгуулалтыг түгээн дэлгэрүүлэх, ажилчин ангийг бий болгох г.м. улс төрийн бодлогоор бүс нутаг, үндэстэн, ястануудын уламжлалт дуу, хөгжмийг хязгаарлаж эхлэжээ (Pegg 2001: 249д). Үүнийг дүгнэж хэлэхэд социалист агуулгаар илэрхийлж болохгүй өв анхаарлын гадна үлдсэн байна. Гэхдээ төрийн бодлогын хүрээнд тухайн үед социалист агуулгатай үндэсний хэлбэртэй соёл хөгжих ёстой гэсэн чиг шугамыг баримталж байсан байна. Үүний үр дүнд шинэ коммунист үзэл сурталтай, намын үйл ажиллагаа, эх орон, ардын хувьсгалыг магтсан дуу, хөгжим дуулж, театрын жүжиг шинээр тоглох болсон байна (Marsh 2006; Pegg 2001: 250-256).

Миний судалгаагаар монголчуудын өнгөрсөн түүх, уламжлалт нүүдэлчин ахуй амьдралтай нарийн холбоотой байсан өвөрмөгц ардын дууны төрлүүд мартагдаж, хуучны хөгжмийн зэмсэг тоглодог хүмүүс цөөрөхөд хүрчээ. Мөн ардын уламжлалт хөгжмийн хэрэгслүүдийг гар аргаар хийхээ больж, үйлдвэрт олон ширхэгээр нь үйлдвэрлэн ө.х. „*factory-made musical instruments*” (Marsh 2006: 297) орон даяар хэрэглэн тоглох болсон байна. 1990-ээд онуудад Архангай аймагт хийсэн Marsh-н судалгааны явцад тэнд уламжлалт биелгээ бүжиг, татлага хөгжим тоглож чадах мэргэжлийн хүнгүй болсон тул социалист нийгэмд „*a region long considered to be less developed and more traditional*” гэж үзэгдэж байсан Увс аймаг руу хүн илгээж, тэнд хүмүүсээ сургах гэж байгаа тухай тэмдэглэжээ (мөн тэнд: 302). Ийнхүү социалист нийгмийн шинэ соёл төлөвшүүлэх ажлын явцад уламжлалт соёлын зарим зүйл мартагдах тийшээ ханджээ. Гэвч эл байдал 1990 оны ардчилсан өөрчлөлтүүдийн үр дүнд өрчлөгдсөн байна.

Монголчуудын соёлын өвийн тухай ойлголт нь өнөөдөр Монгол Улсын засгийн газар тухайлбал Боловсрол, Соёл, Шинжлэх Ухаан, Спортын Яам болон харьяалагдах агентлаг газруудаар соёлын өвийн бодлогоор тодорхойлогдож

судалгааны материалыг Рэнчин 1979: 165-174; хөдөө орон нутаг, тэр тусмаа баруун аймгуудаар 1989-1998 хооронд явж уртын дуу, хөөмий, морин хуур г.м. монголчуудын ардын язгуур урлаг, үлгэр туульсийн түүх, утга, ач холбогдлын тухай дэлгэрэнгүй судалсан Pegg 2001 уншина уу.

байна. 2005 онд Монгол Улс ЮНЕСКО-н “Соёлын биет бус өвийг хамгаалах тухай конвенц”-д нэгдэн орсноор² соёлын өвийн бодлогодоо том алхам хийсэн байна. ЮНЕСКО-н дэлхийн бусад гишүүн орнуудад нь үйлчилдэг санамж бичиг, конвенцүүд Монгол улсын соёлын өвийн бодлогыг тодорхойлоход нь нөлөөлж, өнөөдөр тус улс соёлын өвөө энэ байгууллагын зарчмаар “биет” ба “биет бус соёлын өв” хэмээн хоёр бүлэгт ангилж байна. Дээр дурдагдсан монгол ардын дуу, хөгжим, бүжиг г.м. урлагын өв цаашилбал нүүдэлчин ахуйтай холбоотой зан үйлийг хадгалан тээж яваа хүмүүсийг бүртгэх компанит ажлыг 2010-2013 оны хооронд орон даяар явуулж, “биет бус соёлын өв”-ийг бүртгэсэн байна. Мөн эртний булш, хиргэсүүр, хадны сүг зураг зэргийг “соёлын биет өв” хэмээн бүртгэсэн нь соёлын өвийн бодлогын нэг том зорилт байсан нь мэдээж хэрэг.³

Өнөөгийн байдлаар ЮНЕСКО-н “Дэлхийн соёлын биет бус өвийн жагсаалтад” Монгол Улс нийт 13 соёлын биет бус өвийг бүртгүүлжээ. Үүнээс “Хүн төрөлхтний соёлын биет бус өвийн төлөөллийн жагсаалт”-д: морин хуур хөгжмийн уламжлалт урлаг (2008), уртын дуу (2008), Монгол Наадам (2010), хөөмий (2010), Бүргэдийн баяр буюу шувуучлахуй (2010), монгол гэрийн уламжлалт урлал, зан үйл (2013), шагайн харваа (2014); “Яаралтай хамгаалах шаардлагатай соёлын биет бус өвийн жагсаалт”-анд: монгол тууль (2009), уламжлалт бүжиг – бий биелгээ (2009), цуур хөгжмийн уламжлалт урлаг (2009), лимбэчдийн уртын дуу тоглох уламжлалт арга-битүү амьсгаа (2011), уран бичлэг (2013), ботго авахуулах зан үйлийг (2015) тус тус бүртгүүлжээ.⁴ Харин ЮНЕСКО-гийн “Дэлхийн дурсамж” хөтөлбөрийн баримтат өвийн жагсаалтанд 4 баримтат өвийг бүртгүүлсэн байна. Үүнд: Лувсанданзаны Алтан товч (2011), монгол Шунхан Данжуур (2011), Есөн эрдэнийн Ганжуур (2012 он), Сахиусан Дара Эх судар (2014 он) тус тус болно.⁵ Ийнхүү Монгол Улс жил ирэх бүр энэхүү байгууллагын жагсаалтанд ямар нэгэн зан үйл, урлаг, дуу хөгжмийн төрөл, эртний үнэ цэнэт гар бичмэл, буддын шашны ном шастир цаашилбал байгалийн дурсгалт газрыг бүртгүүлэхийг хичээн ажиллаж, тус байгууллагын дүрмээр тогтмол шинэ өргөдөл тавьдаг байна. Энэхүү шургуу хичээл зүтгэлд, монгол ардын уртын дууг БНХУ-тай хамт өөрсдийн соёлын биет бус өв хэмээн 2005 онд, харин БНХУ хөөмийг өөрсдийн соёлын биет бус өв

² Монгол Улс ЮНЕСКО-д 1962 онд гишүүнээр элсэн орсон. ЮНЕСКО-н конвенцид нэгдэн орсон тухай мөн тус улсын үүргийн тухай дэлгэрэнгүйг Center of Cultural Heritage 2012: 31д үзнэ үү.

³ Энэ компанит ажлын тухай дэлгэрэнгүйг жишээлбэл Altangerel 2014 харна уу.

⁴ Yundenbat 2011; <http://www.monheritage.mn/mn/intangible/UnescoIch.aspx> (сүүлд орж үзсэн 2018-3-28).

⁵ <http://www.unesco.mn/p/230> (сүүлд орж үзсэн 2018-3-30).

хэмээн дангаараа 2009 онд дээрх байгууллагын жагсаалтанд бүртгүүлсэн явдал нь нэг том түлхэц болсон нь дамжиггүй.⁶ ЮНЕСКО оорийн гишүүн орнуудын адил Монгол Улсад ардын уламжлалт дуу хөгжим, эртний бичиг соёлын үнэт өв, нүүдэлчин ахуйн зан үйлийг устаж үгүй болохоос хамгаалах, тэдгээрийг сэргээн хадгалан авч үлдэх тал дээр анхааран ажилладаг нь сайшаалтай хэрэг.

Миний бодлоор Монгол Улсын засгийн газар, яам агентлагууд өнөө оорсдийн соёлын өвийн тухай асуудалд ЮНЕСКО-н зарчмыг баримтлан бодлогоо явуулж байгаа нь маш асуудалтай явдал юм. Үүний оронд монголчуудын соёлын өв гэж яг чухам ямар зүйлийг хэлж байгааг өнгөрсөн түүх, монголчуудын уламжлалт олон царт амьдралын хэв маягаас эргэн харах хэрэгтэй мэт. Дээрх олон улсын байгууллага нь гишүүн орнуудынхаа дотоод асуудал, соёлын бодлогод хутгалдан орж, тодорхой улс төрийн сонирхлоор үйл ажиллагаагаа явуулдаг хэмээн нэг бус удаа барууны улс, оронд шүүмжлэгдэж байсныг судлаач миний бие энд дурдах ёстой.⁷

Дээр дурдагдсан дэлхийд зарлан бүртгүүлсэн морин хуур, шагайн харваа зэрэг нь монголчуудын соёлын өв мөн гэдэгтэй ямар ч монгол хүн санал нийлнэ. Миний судалгааны үр дүнд монголчуудын уламжлалт соёлын өвийг жирийн монгол хүн өнөөдөр маш өөр өнцгөөс харж байна. Өнөөдөр Монгол Улсын нутаг дэвсгэр дээр тархан амьдарч буй монгол угсааны олон бага ястангууд болон түрэг угсааны казак, тува хүмүүс⁸ өөрсдийн уламжлалт соёлын өвөө маш энгийнээр баялаг зүйлээр тодорхойлж байна. 2014-2016 оны 7-9 сарын хооронд Ховд, Завхан, Говь-Алтай, Хэнтий аймгуудад үндэстэн ястны толоолөлүүдтэй уулзаж, ярилцах явцад тэд олон зуун жилийн турш өөрсдийн өвөг дээдэс, эцэг эхээс нь уламжлагдан хадгалагдаж ирсэн зан үйл, ёс заншил, дуу хөгжим цаашилбал хэл аялгууг өөрсдийн соёлын үнэт өв хэмээн тодорхойлж байлаа. Өнгөрсөн нийгэмд мартагдаж, устаж алга болохын аюулд тулгарч байсан энэхүү хэл аялгуу, дуу хөгжмийн үнэт өв, зан үйлээ тэд өнөөдөр өдөр тутмын амьдралдаа хэрэглэхийг хичээж байв. Өнөөгийн даяаршлын эрин үед өөрсдийнх нь үр хүүхдүүд амьдарч

⁶ Энэ тухай тус улсад их шүүмжлэл, хэлэлцүүлэг өрнөж байв. Үүнд жинь Б.Түвшинтөгс 2010: Шаахайтай хятад хөөмийлж байхыг сонсоогүй л юм байна, <http://www.baabar.mn/article/1270>, (сүүлд орж үзсэн 2018-3-30) уншина уу.

⁷ ЮНЕСКО соёлын өвийг хэрхэн тодорхойлдог, тус байгууллагын гэрээ хэлэлцээрийн тухай шүүмжлэлтэйгээр Ericson (2001) und Lixinski (2013) судалжээ. Энд Монгол Улсын тухай дурдагдаагүй бөгөөд ЮНЕСКО Монголын соёлын бодлогод хэрхэн нөлөөж буйг нарийн судлах хэрэгтэй юм.

⁸ Монгол Улсын нийт хүн амын тоо оноогийн байдлаар 3,177,899 хүрчээ (NSOM 2018). 10 жил тутамд болдог хүн амын сүүлчийн тооллогонд нийт хүн амын 82,4 % халх, 3,9 % казак, 2,8 % дөрвөд, 2,2 % баяд, 1,8 % буяад, 0,2 % тува, 0,01% цаатан буюу духа г.м. хүмүүс байна (NSOM 2011).

буй орчин нөхцөлөөсөө хамаарч өөрийн хэл, аялгуугаа бүрэн төгс эзэмшиж чадахгүй эсвэл гадны соёлыг хэт сонирхон өөрсдийн ёс, зан заншлаа үл тоомсорлох болсонд энэ хүмүүс санаа зовж байлаа.⁹ Тодорхой нэг зан үйл, дуу хөгжим, гар урлалыг төгс эзэмшсэн авъяаслаг дуучин, хөгжимчин, уран дархан хүмүүс нь цөөрч эсвэл өндөр насанд хүрч, амьдралын жам ёсоор нас барж, өв соёлоо хойч үедээ зааж, өвлүүлж чадахгүй байгаад мөн тэд санаа зовж байв.¹⁰ Эдгээр хүмүүст дээрх ЮНЕСКО-н жагсаалт нь чухал бус ба ихэнх нь үүний талаар огт сонсоогүй байсан юм.

Өнөөгийн Монгол Улсад оршиж буй соёлын өвийн тухай энэхүү бие биенээсээ ялгаатай ойлголтууд нь хичнээн хоёр өөр өөр төвшинд яригдаж буй ялгаатай асуудал боловч монголчууд гэж чухам хэн бэ, Монгол Улс гэж ямар соёлын өвтэй улсыг хэлж байна вэ гэсэн асуултанд тодорхой хариулт өгч байна. Эцэст нь энэ бүх асуудал нь тус улсын өнгөрсөн түүх, монголчуудын туулан өнгөрсөн амьдралын хэв маягтай нягт холбоотойг тод харуулж байна. Өнөөдөр энд амьдарч буй бүх монгол ба цөөн тооны түрэг угсаатанууд олон мянган жил нүүдлийн хэв маягаар мал аж ахуй эрхлэн, эсгий дугуй гэртээ байгаль орчинтойгоо нарийн холбоотой амьдарч ирэх явцдаа өөрсдийн хэл, аялгуу, дуу хөгжим, гар урлал, судар бичгийн соёл, амьдрах зан үйлийн ёс дэгээ бүтээж байсан байна. Энэ угтаараа тэд монгол гэрийг урлах арга, түүнтэй холбоотой зан үйлийг дээр дурдсанчлан “Хүн төрөлхтний соёлын бист бус өвийн төлөөллийн жагсаалт”-д 2013 онд бүртгүүлсэн нь мэдээж хэрэг. Ингээд монгол гэрийн түүхэн хөгжлийг товч задлан үзье.

⁹ Жишээлбэл: 2016 онд 8 сард хийсэн хэргийн судалгааны үеэр Ховд аймгийн Буянт сумын 80 гаруй настай тува өвгөн, ач хүүхдүүд нь өнөөдөр тува хэлээрээ бүтэн зов ярьж чадахгүй байгаа тухай ярьж байлаа. 2014 оны зун Хэнтий аймгийн Өлзийт тосгонд амьдарч буй 24 казак орхийн нэг, 40 гаруй настай нэгэн казак эцэг хүүхдүүд нь казак хэлээрээ ярьдаг боловч дуу, шүлэг бүтнээр нь дуулж, уншиж чаддаггүй гээд хүүхдүүдээ төрөлх хэлийг нь сайн эзэмшүүлэхийн тулд сургуулийнх нь амралтаар Налайх руу “Казак үндэсний сургалт”-анд явуулдаг гэж ярьж байв. Монголын баруун ба зүүн хаягсаарт амьдарч буй эдгээр үндэсний цөөнхүүдийн хүүхдүүд монгол сургуульд хэл хэлээр сурдаг.

¹⁰ 2015 оны зун Хэнтий аймгийн Ондорхаан хотод 40 гаруй настай уран дархан Цогтбаатартай уулзаж ярилцлага авахад өөрийнхөө Хэнтийн Батноровын Тожил хийцийн уран дарханы 4 дох үеийн цөөхөн төлөөлөлийн нэг гэж байв. Монгол Улс даяар Хан Хэнтийн Тожил хийц хэмээн алдаршсан энэхүү уран дарханы хийцийг Цогтбаатар 16 настайдаа сурчээ. Тэрбээр ярилцлагандаа өнөөгийн хүүхэд, залуучууд дунд уран дархны үйлийг сонирхдог хүн цөөхөн болсон гэж дурдаж байлаа (Тожил хийцийн уран дарханы тухай Chuluunbat 2013 уншина уу).

Монгол гэрийн түүхэн хөгжил

Төв Азийн нутгаар нутаглаж байсан овог, аймгууд анх М.Э.Ө IV–III мянган жилд зэрлэг амьтан, тэр дундаа үхэр, хонь, морь гэх мэтийг гэрийн тэжээвэр мал болгон, мал аж ахуй эрхлэх болсон байна (Майдар, Дарьсүрэн 1976: 61). Энэ үеэс эхлэн өнөөгийн монголчуудын эртний өвөг удам малаа даган өвсний соргог, усны ундаргыг даган өргөн уудам нутагтаа нүүдлэн амьдрах болжээ.

Майдар, Дарьсүрэн нарын судалгаагаар энэхүү малчин овог аймгийн анхны орон сууц нь “эрүкэ” байжээ: “(...) 50 шахам мянган жилийн тэртээ амьдарч байсан хүмүүсийн дунд дэлгэрсэн сууцны хэлбэр бол малтмал газар сууц, эрүкэ, мөн гишүү, шургааг, мөчрөөр барьдаг урц байлаа” (Майдар, Дарьсүрэн 1976: 49). Энэ нь манай эриний VIII-р зууныг хүртэл “овоохой”, “шовоохой”, “тэрэгт сууц”, Хүннү нарын “түрэг гэр” буюу “эсгий гэр” болон хөгжжээ (мөн тэнд). Яваандаа “ханат гэр” нь байгалийн үзэгдэл, нүүдэлчин хүмүүсийн амьдралын хэв маяг, хэрэгцээнд тохирон улам хөгжиж, XVII-р зуун гэхэд монгол урчуудын ур ухаан, эрдэм чадварын хүчинд илүү их боловсронгуй болж, өнөөдрийн хэлбэрээ олох хүртэл хөгжсөн байна. XX-р зууны эхэн хүртэл том ноёд, баячууд “гэрийнхээ дээгүүр хөлт өрх, халз тавин” (мөн тэнд: 93), хээ угалзаар бүрсэн, “гоёлон чимсэн хөлтрөгтэй” гэрт амьдарч (Баатархүү, Одсүрэн 2016: 225), харин хүн амын дийлэнх нь бүрээсгүй, эсгий бор гэрт амьдарч, нэн ядуу хэсэг нь орон гэргүй, урц овоохойд амьдарч байв.¹¹ 1950-аад оноос эрчимтэй өрнөсөн хөдөө аж ахуйн нэгдэлжих хөдөлгөөн, түүний дараах социалист бүтээн байгуулалтын үед эсгий бор гэр нь гадуураа цагаан бүрээстэй болжээ. Мөн энэ үеэс эхлэн эрчимтэй явагдсан “хотжуулах” үйл явцад олон мянган хүмүүс түүхэндээ анх удаагаа нүүдэлчин амьдралын хэв маягийг орхиж, суурин амьдралд шилжин, европ загварын байшин, орон сууцанд орж амьдрах хүмүүсийн тоо эрс нэмэгджээ. Sneath-н судалгаагаар Улаанбаатар, Дархан, Эрдэнэт хотод оршин суугчид гэртээ халаалалт, тог цахилгаан, халуун ус, телевизор, утастай тухтай орчинд амьдрах болсон ч, ихэнх нь нүүдлийн амьдралын хэв маягийг ямар нэгэн хэмжээгээр мэддэг хэвээр байсан байна: „(...) *Social and kinship networks cross the boundaries between the rural and the urban so that virtually all pastoralists have urban relatives and friends. The speed with which urbanization had been carried out in the 1950s-1970s meant that most urban residents at that time had been born in rural localities, and the large families usually contained rural and urban members*“ (Sneath 2006: 157).¹² Энэ

¹¹ Майдар, Дарьсүрэн 1976: 95; Altangerel 2015: 193 харна уу.

¹² Илүү дэлгэрэнгүйг нь Humphrey, Sneath 1999: 209-300, хамаатан садан, ах дүүсийн хоорондын

үзэгдлийн дүгнэж үзэхэд хичнээн олон мянган хүн хот суурин газрын иргэд буюу “хотынхон” болсон байсан ч тэд хөдөө орон нутгийн амьдрал ахуй, тэр тусмаа малчидтай холбоотой байж, улмаар монгол гэр түүнтэй холбоотой амьдралын хэв маяг, ёс заншлын талаар тодорхой мэдлэгтэй байжээ.¹³ Үүнийг тодруулбал тэр үед монгол гэр хүмүүсийн аж төрөх ёсноос бүр мөсөн алга болоогүй байсныг харуулж буй бөгөөд мөн монгол гэр нь тэдний амьдралд нь чухал байр суурийг эзэлж, монгол ахуй, монгол ёс заншилтай нь нарийн холбож байсныг харуулсан явдал юм.

Монгол гэрийн утга, ач холбогдол

Монгол гэр нь монголчуудын өнгөрсөн түүх, уламжлалт ёс, зан заншил, түүний хөгжил, өөрчлөлт шинэчлэлтэй нарийн холбоотой гэдгийг өмнөх хэсэгт тодорхой тусгасан билээ. Олон мянган жилийн тэртээгээс монгол хүн монгол гэрт амьдарч эхэлснээс хойш хүн болж төлөвших, бие бистэйгээ харьцах, амьдрах ухаанд сурах, дэлхийг таньж мэдэх, байгаль орчинтойгоо харьцах гэх мэт олон эрдэм ухаанд суралцахад нь монгол гэр гол үүргийг гүйцэтгэж байж. Хүмүүсийн хоорондын харьцаан дахь монгол гэрийн үүргийн тухай Humphrey: *“The round tent was virtually the only dwelling known in Mongolia, apart from Buddhist monasteries, and it was the focus for relationships between people widely separated by daily occupations”* (Humphrey 1974: 1) гэж дүгнэсэн байна. Гэрийн оройн зай доторх хамгийн хүндэтгэлтэй газар хойд тал буюу хоймор, эр, эм хүйсээр хязгаарлагдсан баруун ба зүүн тал, гэрийн дунд орших гал голомт, хаалга үүд нь нийлээд *„a kind of microcosm of the social world of the Mongols“* (мөн тэнд) бөгөөд тус тусдаа гүн утга агуулгатай, жижиг ертөнцийн тухай ойлголт юм. Монгол гэр доторх энэ жижиг ертөнцүүд нь биеэ даасан орон зайнууд ба хоорондоо нарийн уялдаа холбоотой, маш гүн утга учиртай бэлгэдэлүүдийг агуулдаг гэж Schukowskaja (1996) судалсан байна. Эдгээр бэлгэдэлүүдэд гэр доторх бүх орон зай захирагдаж, тэдгээрийн тусламжтайгаар гадаад ертөнцөөс тусгаарлагдаж, улмаар “өөрийн-харийн”, “дотор-гадаа”, “эерэг-сөрөг” хэмээх хил хязгаарын хооронд хөдөлж, эцэст нь эдгээр бэлгэдэлүүд нь хамгаалагчийн үүрэг гүйцэтгэдэг байна (Schukowskaja 1996: 20). Судлаачдын энэ дүгнэлтийг тодруулахад монгол

холбооны талаар Humphrey, Sneath 1999: 139-147 уншина уу.


¹³ “Хотынхон” ба “хөдөөнийхон” нэр томъёолууд монголын нийгэм, ард түмний дунд ямар ойлголтоор тархсан, Улаанбаатар буюу хөдөө орон нутагт амьдарч буй хүмүүсийн амьдралын хэв маяг, тэдний үзэл бодлын тухай харьцуулж судалсныг жишээлбэл Sneath (2006: 156f), Altangerel (2015: 85f) уншина уу.

гэрийн тусгаарлагдсан орон зай доторх, нүдэнд үл харагдах бэлгэдэлүүд нь бүгд монголчуудын олон мянган жилийн өмнөөс путаг ус, байгаль орчноо хайрлаж, тэнгэрийг шүтэн, малаа хариулж, хүрээлэн буй орчинтойгоо нарийн холбоотой амьдарч ирсний тод илэрхийлэл.¹⁴ Тэдний уламжлалт зурхайн ба тооны ухаан, он тоололын бичиг, нарны цаг нь үүнтэй бас л салшгүй холбоотой. Жишээлбэл: багана нь доороос дээшээ чиглэн ө.х. газрыг тоонотой холбогч гэдэг утгаараа өнгөрсөн, ирээдүй, одоо цагийг харуулна (Schukowskaja 1996: 24). Мөн гэрийн баганыг “галын сүнс” гэж үзэн (Майдар, Дарьсүрэн 1976: 107д), улмаар хоёр багана нь гэрийн тулгуур хэмээн эрэгтэй, эмэгтэй хоёр хүнийг илэрхийлсэн, гэр бүлийн бат бэх оршин тогтнохыг харуулах жишээтэй (Altangerel 2015: 84). Гэрийн дунд орших гал зуухны хэсэг нь тэр гэрт хамгийн голлох байр суурийг эзэлж, тэр айл гэр үүссэн гал голомт хэмээн цаашдаа оршин тогтнохын бэлгэдлийг илэрхийлнэ (Schukowskaja 1996: 20; Altangerel 2015: 68; Цэрэнханд 2015: 67-72). Ахмад настнаа хүндэтгэж гэрийн хоймортой суулгах, шүтдэг бурхан эсвэл гэр бүл, хамаатан садны хайртай дотно хүмүүсийнхээ зургийг хоймортой залах зэрэг нь бас л энэ бэлгэглэх ёстой нарийн холбоотой (Humphrey 1974: 2). Монголчууд эргнээс баруун зүгийг эрхэмлэн дээдэлж, гэрийн баруун талаа эр хүний тал хэмээн үзэж, мөн эцэг эх буюу гал голомтны эс үүсвэр болох их гэрээ баруун талдаа барьж ирсэн жишээг энд бас дурдаж болно (мөн тэнд).¹⁵

Монгол гэрийн доторх оройн зайны ертөнцтэй нарийн холбоотой бас нэг ухаан бол нарны гэрэл хаана тусаж байгаагаар өдөр тутмын амьдралдаа цаг тодорхойлох явдал байлаа (Schukowskaja 1996: 34; 43). Судлаач миний дүгнэлтээр өнгөрсөн зууны дундуур монголчууд суурин амьдралд шилжин баруунд үйлдвэрлэсэн ханын цагийг хэрэглэх хүртэл тэд өргөнөөр энэхүү уламжлалт нарны цагаар баримжаалан малаа хариулж, өдөр тутмын ажлаа эрхэлж байсан байна.

¹⁴ Дэлгэрэнгүйг Баатархүү, Олсүрэн 2016: 47д; 98д үзнэ үү.

¹⁵ Монгол гэр доторх бүх орон зайны утга жишээлбэл “хоймор”, гэр доторх эд зүйлийн бэлгэдэлийн тухай (Майдар, Дарьсүрэн 1976: 107д; Schukowskaja 1996: 16-26 ; Humphrey 1974) уншина уу.



Зураг 1: 12 амьтнаар нэрлэсэн монгол гэр доторх цаг тоололын систем, зураг: Ганчимэг Алтангэрэлийн 2018¹⁶

Монгол гэрийн орон зайг 12 хэсэгт хуваан 12 амьтны нэрээр нэрлэсэн цаг тоолол нь өнгөрсөн зууны дунд үе хүртэл ажил хэргээ явуулахад гол үүрэг гүйцэтгэж байжээ. Тухайлбал, морин цагт гэрийн тооноор орж ирэх нарны тусгал яг гэрийн хойморт тусна г.м. Миний хээрийн судалгааны явцад хөдөө орон нутагт малчид энэхүү зан үйлийг өнөөг хүртэл гэр орны ажил, мал ахуйгаа эрхлэхдээ хэрэглэсээр байгаа нь харагддаг. Харин улс төрийн хүрээнд энэ цаг тоололын системээс морин цагийг илүү чухалчлах болсон нь ажиглагдаж байна. Жишээлбэл: улс төрийн том арга хэмжээ, ёслол хүндэтгэлийн үйл ажиллагаа, Наадам г.м. ихэвчлэн морин цагт буюу 10 цагт¹⁷ эхэлж байна.

Монгол гэр дотор хэрэгжиж байсан “гэрийн хүмүүжил” буюу хүүхдийг багаас нь аав, ээж, ахмад настны сургаалаар амьдрах ухаанд сургаж, ажилтай, эрдэм номд дуртай болгон хүмүүжүүлэх аргыг бас энд дурдах хэрэгтэй. Үүнд хүүхдийг багаас нь ахмадаа хүндэтгэх ёсонд сургах нь энэ “гэрийн хүмүүжлийн” нэг гол зорилт байв (Баатархүү, Олсүрэн 2016: 57д). Энэ мэтчилэн миний судалснаар монгол гэрийн доторх орон зай, тэдгээрийн гүн утга агуулгатай бэлгэдэлүүд,

¹⁶ Ашигласан эх сурвалжууд Майдар, Дарьсүрэн 1976: 50, Schukowskaja 1996: 43.

¹⁷ Морин цаг нь зуны цагт 3 сарын 23-аас 9 сарын 22 хүртэл 9.40 - 12.40 хооронд, харин өвлийн цагт 9 сарын 23-аас 3 сарын 22 хүртэл 11.40 - 13.40 цагийн хооронд тохионо.

монголчуудын өнгөрсөн түүхэндээ бүтээсэн шинжлэх ухааны олон салбаруудтай хоршин ойролцоогоор XX-р зууны төгсгөл хүртэл дийлэнх монголчуудын амьдралд маш чухал байр эзэлж байжээ. Үүнийг Humphrey „*Even if an individual herdman's family is prosperous and has fitted out its tent in luxurious modernity, the time has not yet come when past arrangements can be forgotten*” (Humphrey 1974: 2) хэмээн тодорхойлжээ. Түүний судалсанаар Ардын хувьсгалын дараа социалист нийгэмд шинээр багш, намын гишүүн, малын эмч г.м. мэргэжлүүд бий болж, үүнтэй уялдан монгол гэр доторх хүмүүсийн харьцаанд том өөрчлөлт гарсан боловч, „*the rank of each social category*” буюу нийгмийн янз бүрийн давхраа, насны зөрүүтэй холбоотой бие биенээ хүндэтгэх ёсны үндсэн ач холбогдол, утга нь хадгалагдан үлдсэн байна (мөн тэнд). Үүний нэг тод жишээ бол өнөөг хүртэл илүү их хөдөө орон нутагт, гэртээ орж ирсэн ямар ч зочноо хүндэтгэн дээшээ суулгаж, идээ тавьж, цайгаа аягалан, баруун гараараа зочиндоо өргөн барьдаг ёс заншил юм.

Харин Монгол Улс ардчилсан нийгэмд шилжсэний дараа улс төр, эдийн засаг, нийгмийн олон хүчин зүйлээс шалтгаалан монгол гэрийн үүрэг багасаж, түүний утга учир, ач холбогдол нь аажмаар алдагдаж иржээ. Баатархүү, Одсүрэн нарын судалснаар “(...) өнөө цагт монгол гэрийн хэрэглээ багасаж, гэрийн олон төрөл зүйл, гэр урлах уламжлалт арга ухаан үгүй болж, дан ганц үйлдвэрийн нэг хэв загварт шилжиж, гэртэй холбоотой ёс заншил, зан үйл мартагдахад хүрчээ” (Баатархүү, Одсүрэн 2016: 4). Монголчууд хичнээн их суурин амьдралд шилжиж мөн дэлхийг хамарсан даяаршлын нөлөөнд хөл даган хөгжих тусам, монгол гэрийн төгс утга учир, түүний доторх орон зайн ач холбогдол, олон утгатай бэлгэдэлүүд ба гүн ухааны ойлголтууд, гэр доторх хүмүүсийн хоорондох харьцааны уламжлалт ёс заншил, цаашилбал нүүдлийн соёлын хэв маягтай холбоотой олон зан үйлүүд мартагдахад хүрсэн нь судлаач надад ажиглагдаж байна. Өмнөх хэсэгт бичсэнчлэн дөчөөд жилийн өмнө бараг монгол хүн бүрийн мэддэг байсан ёс зан үйл, түүний цаад утга учир, ач холбогдлыг өнөөдөр төв суурин газарт амьдарч буй олон мянган монголчууд мэдэхгүй болсон байна. Үүнд монгол гэрт амьдарч буй айлд ороод хүндэтгэх ёсны хамгийн эрхэм зүйл болох айлын хойморт нь заларч болохгүй, хоёр баганынх нь хоорондуур гарч болохгүй, галд нь хог цаасаа хийж болохгүй г.м. дурдаж болно. Өөрөөр хэлвэл монгол сэтгэлгээний өв залуу хойч үед уламжлагдахгүй мартагдахад хүрч, аажмаар алдагдаж байна гэж үзэж болох юм.

Монгол гэрийн дүр зураг өнөөдөр

Социалист байгуулалтын жилүүдэд хөдөө, орон нутгаас Улаанбаатар хотод орж ирж амьдрах явдлыг нилээд хянадаг байсан бол 1990-ээд онуудын ардчилсан өөрчлөлтийн жилүүдэд хүн амьдрах орчноо өөрөө сонгох эрхтэй болсон. Үүний дагуу мөн улс, оронд тулгарсан нийгэм, эдийн засгийн шилжилтийн хүнд хэцүү үед олон мянган хүн ажлын байр хайж, орон нутгаас хот суурин газрыг зорин нүүж эхэлсэн. Ингээд бүх нутаг дэвсгэрийг хамарсан төвийн бүс ба аж үйлдвэрлэл эрчимтэй хөгжсөн төв, хойд бүсийн хот суурин газрууд руу чиглэсэн их нүүдэл өрнөсөн. Ялангуяа нийслэл Улаанбаатарыг зорьсон шилжих хөдөлгөөнд эрүүл мэнд, боловсролын илүү боловсронгуй тогтолцоо зэрэг үзүүлэлтүүд нөлөөлсөн. Харин байгаль, цаг уурын гамшиг буюу жил дараалан тохиолдсон зуданд малаа алдсан олон малчид амьдралын эрхээр аргагүйн эрхэнд хот, суурин газар буюу Улаанбаатар хотыг зорин нүүжээ.¹⁸ Шинээр суурин амьдрах үйл явц нь маш эмх замбараагүй явагдаж, олон мянган айл өрх дуртай газраа сонгон зөвшөөрөлгүй гэрээ барин суурьшсан. Энэ нь хотын төлөвлөлтөнд сөрөг нөлөө үзүүлэн хожим нь олон айл өрхийг албадан өөр газарт нүүлгэх асуудалд хүрч байсан нь ажиглагдсан. Хотын засаг захиргаа ч нүүдлэн ирэгсэдийг хүлээн авч, нарийн боловсруулсан төлөвлөгөөний дагуу бодлоготойгоор суурьшуулаагүй нь харагдаж байлаа.


Энэ их шилжилт хөдөлгөөний үр дүнд нийслэл болон аймгийн төвүүдийн захын гэр хороололын хүрээ тэлж, тэнд амьдрах хүмүүсийн тоо огцом нэмэгдсэн.¹⁹ Нийслэлийн Статистикийн Газрын мэдээгээр өнөөдөр Улаанбаатар хотод нийт 386,218 өрх айл амьдарч байна. Үүнээс 1617 өрх нь тусдаа хувийн тохилог орон сууцанд, 169,436 өрх нь нийтийн орон сууцанд, 2045 өрх нь гэр хороололд хашаандаа тохилог байшинд, 110,220 өрх нь хашаандаа жижиг байшинд, харин 102,719 өрх монгол гэрт амьдарч байна.²⁰ Орон гэргүй айл, өрхүүд энэ статистиكت ороогүй байна.

¹⁸ Зудны тухай илүү дэлгэрэнгүйг Altangerel 2017: 28 үзнэ үү.

¹⁹ Улаанбаатар хотын гэр хороололын тэлэлт, тэнд амьдарч буй иргэдийн амьдарлын нөхцөл байдлын тухай дэлгэрэнгүй судалгааг жишээлбэл Taraschewski (2008) үзнэ үү.

²⁰ Учрал: Нийслэлийн нийгэм, эдийн засгийн онцлох тоо баримтуудыг танилцууллаа (<http://ikon.mn/n/196k>, сүүлд орж үзсэн 2018-4-7)

1935-2017 онуудын Улаанбаатар хотын нийт хүн ам, нийт орх, гэр хороололд монгол гэрт амьдардаг өрхийн тоо



Зураг 2: 1935-2017 онуудын Улаанбаатар хотын нийт хүн ам, нийт орх, гэр хороололд монгол гэрт амьдардаг өрхийн тоо, зураг: Ганчимэг Алтангэрэлийн²¹

Нэгэнт урдаас сайн төлөвлөгдөөгүй гэр хорооллууд буй болсон нь олон асуудлыг бий болгожээ. Гэр хороолол томорч, тэнд амьдардаг хүмүүсийн тоо ихэсэхтэй зэрэгцэн овлийн улиралд Улаанбаатар хотын агаарын бохирдол, утаа угаар ихэссэн. Монгол гэрт амьдарч буй хүмүүс хүйтний улиралд гэрээ дулаацуулж, хоол, ундаа хийхийн тулд ихэвчлэн хямд өртөгтэй түүхий хүрэн нүүрс авч, түлдэг.²² Дөрвөн уулын дунд, нам хөнгөр газар оршдог Улаанбаатар хотод агаарын солилцоо хангалтгүй явагддагаас гэр хороололын айлуудын хувийн байшин ба монгол гэрийн яндангаас гарч буй утаа агаартай тогтож үлддэг. Мөн энэ айлууд цэвэр, бохир усны системд холбогдоогүй учраас хашааныхаа нэг онцогт нүх ухаж, модон жорлон барьж хэрэглэдэг. Ихэвчлэн энэ шалтгаанаас болж тус хотын хөрс маш ихээр бохирдсон гэж нэг бичиг судалгааны ажлууд дүгнэсэн (Бямбасүрэн et al. 2017: 32).²³ Зарим аймгийн товүүд, бусад хотууд мөн л гэр хороололын яндангаас гарч буй утаанаас шалтгаалан овлийн улиралд агаарын бохирдол ихтэй, утаа угаартай болсон гэж мэдээлж байна (Schaller 2015: 35).

²¹ NSOM; Нийслэлийн Статистикийн Газар 2018

²² Нэн ядуу хүмүүс даарахгүйн тулд хог цаас, машины хуучин дугуй г.м. шатааж гэрээ дулаацуулдаг гэж зарим эх сурвалжууд мэдээлдэг (жнь Schaller 2015: 35; 37 харна уу).

²³ Ц.Бямбасүрэн, Б.Хүүхэнхүү, Шабанова Е.В., Васильева И.Е., Б.Энхзул 2017: Улаанбаатар хотын өнгөн хөрсөн дэх хүнд элементүүдийн хөдөлгөөнт хэлбэрийн агуулыг судалгаа. In: Proceedings of the Mongolian Academy of Sciences, Vol. 57 No 03 (223) 2017.

Ийнхүү өнөөдөр нийгэмд монгол гэр нь байгаль орчинтой хамааралтай том асуудалд холбогдон, хүмүүсийн амьдран буй орчныг бохирдуулагч, сүйтгэгч, гэр хороолол нь бүх болж бүтэхгүй байгаа зүйлийн эх үүсвэр хэмээн маш сөрөг утгаар ойлгогдох болжээ. Миний бодлоор энэхүү зовхон нэг онцгоос харсан ойлголтонд гэр хороололд монгол гэрт амьдарч буй хүмүүс гол буруутай бус. Харин 1990 оноос хойш олон удаа солигдсон, улс төрийн тогтворгүй засгийн газрын алдаатай бодлогоос үүдэлтэй.²⁴ Хөдөө, орон нутгаа хөгжүүлж, тэнд хангалттай ажлын байр бий болгож, хүмүүсийн амьдрах тохьтой орчныг бүрдүүлсэн бол тэндээс Улаанбаатарыг чиглэсэн их нүүдэл мэдээж явагдахгүй байх байсан болов уу. Дээр дурдсанчлан Улаанбаатарыг тойрсон өндөр уулнуудад нутгаасаа ачиж ирсэн гэрээ барьж суурьшсан айлуудыг эхнээс нь нарийн бүртгэж, эмх цэгцтэй суурьшуулсан бол өнөөдрийн гэр хороололын замбараагүй тэлэлт болохгүй байсан нь бас мэдээж хэрэг. Улаанбаатар хотын бараг төвд нь байрладаг Дулааны цахилгаан станцууд хүйтний улиралд түүхий хүрэн нүүрсээр ажилладаг гэдгийг бас энд дурдах хэрэгтэй. Мөн тус хотын замын хөдөлгөөнд оролцож буй жижиг машин, тэрэгнүүд, олон нийтийн тээврийн хэрэгсэл болох автобуснууд дийлэнх нь импортоор орж ирсэн, олон жилийн настай хуучирсан байдаг нь агаарын бохирдолд их нэрмээс болдог. Улс төр, засгийн эх баригчдын нөлөөгөөр зарим мэдээлэлийн эх сурвалжууд туйлширсэн мэдээ цацаж, нэг бус судалгааны үр дүн бодит бус байдаг гэдгийг миний бие энд дурдахыг хүсэж байна.²⁵

Социалист нийгмийн үед дээд тал нь 500.000 хүн амьдарна гэж тооцоолж дөрвөн уулын дунд барьсан Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотод ийнхүү өнөөдөр нийт хүн амын бараг тал нь буюу 1,4 сая хүн амьдарч, жилийн дөрвөн улиралд зам нь түгжирсэн, газрын хомсдол, агаар, хөрсний бохирдолтой, саяхнаас ундны усны хомсдолд орж байгаа гэсэн олон асуудлыг дагуулсан хот болон хөгжжээ.

Энэ бүх байгаль орчинтой холбоотой асуудалд монгол гэр буюу гэр хороолол шүүмжлэлийн гол бай болж байгаагаараа маш онцлог юм. Энэ тухай Баатархүү, Одсүрэн (2016) нар дараах дүгнэлтийг өгч байна: „ (...) Гэр гэдгийг бид гэр

²⁴ Олон засгийн газруудын хайхрамжгүй хандлага, бодлогын талаар Schaller 2015: 39; 41 үзнэ үү.

²⁵ Улаанбаатарын агаарын бохирдлын талаар хийсэн сүүлчийн судалгаанд 80 % нь гэр хороололын айлуудаас, 13 % тээврийн хэрэгсэлээс, 7 % уурын зуухны яндангаас гардаг гэж үнэлэгджээ (Пагчаа 2018: Гурван жилийн өмнө утаа 20 хувь багассан нь үтэн болов уу? <http://ikon.mn/n/16z1>, сүүлд орж үзсэн 2018-1-10). Харин Schaller-н судалгаагаар Улаанбаатар хотын агаарын бохирдлын 88 % нь дараах гурван гол эх үүсвэрээс гардаг. Үүнд 42 % гэр хороололын айлуудын түлж буй төрөл бүрийн түлшнийгээс, 27 % нь нүүрс түлж ажилладаг ДЦС-аас, 19 % нь том барилга байгууламжийг халаах, үйлдвэр аж ахуйн нэгжүүдийн нүүрсээр ажилладаг уурын зуухны яндангаас гардаг. Үлдсэн хэсэг нь машин тээврийн хэрэгсэлээс гарч буй газ, гудамжны жижиг тоосонцор, ил задгай газар шатааж буй хог хаягдлаас гардаг байна (Schaller 2015: 37).

хороолол гэдэгтэй холбон ойлгож, ад шоо үзэх болжээ” гээд энэ асуудал нь монголчуудын олон зуун жилийн түүхтэй монгол амьдрах ахуй, ёс зан заншилд эсрэгээр нөлөөлж байгааг дурдсан байна (Баатархүү, Одсүрэн 2016: 4). Мөн Bruun, Narangoa нар энэ хурц асуудалд шүүмжлэлтэй хандан БНХУ-н Өвөр Монголын Өөртөө Засах Улсын нийслэл Хөх хот,²⁶ мөн Улаанбаатар хот дахь монгол гэрийн дүр зургийг харьцуулан дүгнэсэн байна: „*Both Ulaanbaatar, the capital of Mongolia, and Hohhot, the capital of Inner Mongolia, have the traditional Mongolian dwelling, the yurt or ger. Ironically, this key Mongolian symbol has become the emblem of poverty and backwardness in Ulaanbaatar, while the few yurts displayed in Hohhot have become a symbol of ethnicity and one of the main points that distinguish Hohhot from other cities in China*“ (Bruun, Narangoa 2006: 12). Ийнхүү өнөөдөр монгол гэр нь улс төрийн хүрээнд мөн Улаанбаатарын төвийн ихэнх оршин суугчдын дунд өрөөсгөл утгаар ойлгогдож, байгаль орчны бохирдол, ядуурал, ажилгүйдэл, гэмт хэрэг гэх мэт асуудлуудтай холбогдон, үндсэн утгаа алдаад байгааг судлаач миний бие онцгойлж байна. Монгол Улсын төр өнөөдөр монгол гэрийг төр улсын голомт хэмээн үзэж ирсэн эртний уламжлалыг хадгалахыг хичээж байгааг би тэмдэглэх нь зүйн хэрэг юм. Үүний нэг илрэл бол уламжлалт монгол дархны ур ухаан, гайхамшигт хийцээр үйлдсэн том монгол эсгий цагаан гэрийг Төрийн Хүндэтгэлийн Өргөө болгон барьж, улсын ерөнхийлөгч гадаадын хүндтэй зочдыг хүлээн авч уулздаг ба төрийн өндөр соёрхол шагналыг тэнд гардуулдаг. Төрийн ордоны дотор талбайд Төрийн Өргөө олон ханат цагаан гэрийг байрлуулж, жил бүрийн 12 сарын 29-ны өдөр буюу 1911 оны үндэсний эрх чөлөөний хувьсгал ялсан өдрийг хүндэтгэн гал бадраадаг уламжлал тогтоод хэдэн жилийг нүүрийг үзэж байгааг дурдах хэрэгтэй.

Харин бодит амьдрал дээр монгол гэр нь хөдөө орон нутагт мал маллан амьдарч буй малчид, тэдний ахуй амьдралтай салшгүй холбоотой гэдгийг өнөөдөр монголын нийгэм нэгэн дуугаар хүлээн зөвшөөрнө. Өнөөгийн даяаршлын эрин үед тэд монголчуудын олон мянган жилийн түүхтэй нүүдэлчин амьдралын хэв маягийг хадгалан монгол гэртээ уламжлалт ёс дэгээ даган амьдарч яваа хүмүүс. Малчид өнгөрсөн үед, тодруулбал 1921 оны ардын хувьсгалын дараа баячуул нь хөрөнгөө хураалгаж, ядуучууд нь малтай болж улмаар шинэ нийгэмд “*the revolutionary ard*” (Bulag 1998: 50) хэмээн гол үүрэг гүйцэтгэж байсан. Харин 1950-

²⁶ БНХЯ-н ӨМӨЗО-д амьдардаг монгол угсаатны сүүлчийн нарийн тоог мэдэх боломж олдсонгүй. Харин 2000 оны хүн амын тооллогоор ойролцоогоор 4 сая монгол хүмүүс бүртгэгдсэн байна (Inner Mongolia Demographics, http://www.newworldencyclopedia.org/entry/Inner_Mongolia, сүүлд орж үзсэн 2018-4-8).

аад онуудад нэгдэлжих хөдөлгөөн хүчтэй өрнөхөд зарим малчид хагас суурин амьдралд шилжиж, улмаар социалист бүтээн байгуулалтын явцад Булагийн дүгнэснээр төр засгаас “*the ajilchin working class*”-н дараа тавигдах болж, “*the backward class*” хэмээн үзэгдэж байжээ (Bulag 1998: 50). Булагийн дүгнэснээр энэхүү малчин буюу мал аж ахуй эрхлэгч хүмүүс социалист нийгэмд үл тоогдох болсон нь монголчуудын уламжлалт нүүдлийн ахуй амьдрал, түүнтэй холбоотой ёс заншил, ардын дуу хөгжмийн өвд их сөргөөр нөлөөлсөн байна: “*This ideological upgrading led to repeated campaigns against Mongolian customs, tradition, culture, and even the nomadic way of life, which were labeled as ‘feudal remnants’ contrary to the socialist way of life*” (мөн тэнд). Ийнхүү он цагийн явцад олон янзын учир шалтгаанаар монгол гэртээ амьдран монголчуудын уламжлалт зан үйл ө.х. нүүдэлчин соёлын өвийг тээн яваа малчдын тоо тогтмол багассан байна. 1925 онд улсын нийт өрхийн 87 % малчин өрх байсан бол, 1956 онд 63 % болж, социалист систем задрахын өмнөх жил буюу 1989 онд срдөө 16 % нь малчин өрх байжээ (Altangerel 2018). 2017 онд Монгол Улсад нийт 885.639 өрх бүртгэгдсний 169.740 нь малчин өрх байсан ба энэ нь нийт өрхийн 20 % эзэлж байгаа юм (NSOM 2018). Хүн амын тоо хэдийгээр өсч байгаа боловч мал аж ахуй эрхлэн монгол гэртээ амьдарч буй малчдын тоо жил ирэх тутам цөөрч байгаа нь олон учир шалтгаантай гэж харагдаж байна. Өмнө хэлсэнчлэн байгалийн гамшигт малаа алдах мөн эдийн засгийн хүндрэлтэй байдал, ажлын хүнд хэцүү нөхцөл байдал цаашилбал залуу залгамж халаа дутагдаж байгаа зэрэг олон хүчин зүйлүүд үүнд нөлөөлж байна.²⁷

Гэсэн хэдий ч эхэн хэсэгт дурдсанчлан хөдөө орон нутагт амьдардаг хамаатан саднаараа холбогдон тэндэх амьдралыг мэддэг байсан үе ялангуяа Улаанбаатар хотын төвд оршин суугчдын дийлэнх хэсгийн дунд алга болжээ. Монгол гэрийн жинхэнэ утга учир, түүний доторх оройн зай, түүнтэй холбоотой бэлгэдэлүүд, тэдний ач холбогдол, зан үйлээ огт мэдэхгүй, нүүдэлчин ахуй амьдралаас хол тасархай бараг бүтэн хоёр үе бий болсон нь надад ажиглагдаж байна. Үүнээс шалтгаалан магадгүй монгол гэрийг өрөөсгөл харж сурталчилгааны зориулалтайгаар энэ дүрийг давамгайлуулж, материалаг эд зүйл хэмээн ойлгон эдийн засгийн талаас нь үзэж байж болох юм. Сүүлийн жилүүдэд “*монгол брэнд болгох*”, “*соёлын өвийг брэнджүүлэх*” (Center of Cultural Heritage 2012: 8) нэр томъёоны доор монгол гэр, эхэнд дурдагдсан монголчуудын төрөл бүрийн дуу хөгжим, урлаг, соёлын өвийн эдийн засгийн үр ашгийг тодорхойлж байгаа явдлыг энд дурдаж болно. Мөн аялал жуулчлалын салбарыг хөгжүүлэх зорилготойгоор

²⁷ Энэ тухай дэлгэрэнгүйг Altangerel 2018 уншина уу.

гадаадын улс орнуудын үзэсгэлэн яармаг дээр монгол гэр, нүүдэлчин ахуй амьдралыг „*Nomadic by Nature*“ хэмээн сурталчилж байгаа²⁸ болон нутагтаа үйл ажиллагаагаа явуулдаг олон гэр жуулчны баазууд, амралтын газруудыг нэрлэж болно. Тэнд монгол гэрийг улам боловсронгуй болгож, байнгын халаалт бүхий төхөөрөмж байрлуулж, угаалгын өрөө хийн улмаар хоёр гурван гэрийг хүзүүвчээр холбон гэр хэлбэрийн бүтцийг нь алдагдуулахгүйгээр зочны, унтлагын, гал тогооны гэрийг холбон бүтээсэн нь жуулчны компаниудад үзэгддэг. Энэ нь аялал жуулчлалын компаниудын үйл ажиллагаа, эдийн засгийн ашиг орлогыг нь сайжруулахад мэдээж ололттой сайн зүйл.²⁹ Энэ олон янзын компани ажилууд, сурталчилгаа, бүтээл дээр монгол гэрийн талаарх эдийн засгийн ач холбогдолтой материалаг эд зүйл хэмээх дүр зураг илүү онцгойн товойрч байна гэсэн миний үзэлтэй нэг бус хүн санал нийлэх байх. Харин үүний оронд судлаач миний саналаар монгол гэрт орж ирж буй гадаадын болон дотоодын жуулчдад монгол гэрийн жинхэнэ утга учир, тухайлбал: гэр доторх олон жижиг орон зай, түүнтэй холбоотой бэлгэдэлүүд, хүмүүсийн нас, хүйс, нийгмийн давхрааны ялгаагаар хэрэгждэг ёс заншлуудыг нарийн тайлбарлаж, зааж сургах, сурталчилах аваас монголчуудын нүүдлийн соёлын өвийг жинхэнэ утгаар нь түгээх болно.

Төгсгөл

Монгол гэр нь Монгол Улсын өнгөрсөн түүх, монголчуудын туулж өнгөрүүлсэн нүүдлийн соёл, амьдралын хэв маягтай салшгүй холбоотой. Өнөөдөр тус улсын нутаг дэвсгэр дээр амьдарч буй бүх монгол, түрэг угсаатнууд өнгөрсөн зууны дундаас эхлэн суурин амьдралд шилжих хүртлээ эсгий бор гэр буюу монгол гэрт амьдарч, олон зуун жилийн тэртээгээс өвөг дээдсээс нь хадгалагдан ирсэн нүүдлийн ёс заншлаар амьдарсаар ирсэн билээ. Тэдний өдөр тутмын амьдралд мөн гэр бүл, хүмүүсийн хоорондын харьцаанд монгол гэр нь зөвхөн дотор нь амьдарч суух орон сууц, түүнийг урлах, үйлдвэрлэх, барих, тохижуулах гэх мэт ойлголт бус, харин нарийн утга, агуулгатай том цогц зүйл байжээ. Дотроо олон жижиг ертөнцийг агуулсан, тус тусын биеэ даасан орон зайнууд нь олон талын

²⁸ Жингээлбэл, ХБНГУ-н нийслэл Берлин хотод зохиогддог аялал жуулчлалын ITB үзэсгэлэн яармагт Монгол Улс 2016 онд түнш орноор оролцохдоо дээрх сурталчилгаа явуулж байв.

²⁹ Монгол Улсын Засгийн газар сүүлийн хэдэн жилийн эдийн засгийн хямралын дараа, эдийн засгийн салбараа солонгоруулж, зөвхөн уул уурхайн салбарын хараат байдлаас гарч, хөдөө аж ахуй, аялал жуулчлалын салбарыг хөгжүүлэх тал дээр анхаарч байна. Монголын Аялал Жуулчлалын Холбооны мэдээлснээр 2017 онд Монгол Улсад 471,094 жуулчин ирсэн байна (<http://travelmongolia.org/index.php?newsid=495>, сүүлд орж үзсэн 2018-4-7). 2020 он гэхэд 1 сая жуулчин хүлээж авахыг засгийн газар хичээж байна.

утгатай бэлгэдлийг агуулж, энэ утгаараа монгол гэр нь монголчуудын амьдралын гол цом нь байжээ. Хүний нүдэнд ил харагдах монгол гэрийн олон орон зайнууд нь өргөн утга агуулгатайгаар монголчуудын байгаль орчин, нутаг усаа дээдэлж, галын бурхан, тэнгэрээ шүтэж, гэр бүл, ахмад настнаа хүндэтгэх, мал амьтнаа эрхэмлэх ёс заншлыг бэлгэдэж ирсэн арвин түүхтэй. Энэ нь улмаар монголчуудын сэтгэлгээний онцлогийг илэрхийлсэн хийгээд ижилсэлтэй нарийн уялдаатай байжээ. Нүүдлийн мал аж ахуй эрхлэн амьдарч ирсэн олон зуун жилийн дотор энэхүү бэлгэдлүүд нь үргэлж цагийн явцад өөрчлөгдөн, шинэчлэгдэж, хувьсан өөрчлөгдөж байсан. Харин монголчууд өнгөрсөн зуунд, социалист нийгмийн үед нүүдэлчин амьдралын хэв маягаас суурин амьдралд шилжиж, дараа нь ардчилсан нийгэмд шилжэн орсны дараа монгол гэрийн үүрэг аажмаар хумигдсан байна. Олон хүн орчин үеийн орон сууц, байшинд амьдрах болсонтой холбогдон монгол гэр, түүний ач холбогдол, монгол гэр доторх орой зай, түүний бэлгэдлүүд мөн монгол гэрийн олон зан үйл, ёс заншлууд мартагдахад хүрсэн нь миний судалгааны явцад тодорхой болов.

Улс орны эдийн засаг, нийгмийн олон хүчин зүйлүүд мөн байгалийн гамшигт үзэглүүдээс хамааран хөдөө орон нутгийн олон мянган иргэд ба малчид хот суурин газрыг зорьж, гэрээ барин гэр хороололд амьдрах болсон. Ийнхүү гэр хороолол тэлсээр, монгол гэрт амьдардаг айлын тоо буюу нүүрс түлдэг яндангийн тоо нэмэгдэх тусам монгол гэрийн дүр зураг нийгэмд улам сөрөгөөр үзэгдэх болжээ. Өнөөдөр монгол гэр нь байгаль орчин бохирдуулагч эсвэл эдийн засгийн ач холбогдолтой материаллаг буюу сурталчилгааны эд зүйл хэмээн хоёрхон ойлголтоор хязгаарлагдах болсон нь олон зуун жилийн нүүдэлчин соёлын овтэй монголчуудын түүхэнд маш харамсалтай явдал хэмээн миний бие дүгнэж байна. Хөдөө орон нутагт малаа хариулан монгол гэртээ нүүдэлчин ахуйгаараа амьдарч буй малчдыг эс тооцвол, монгол гэрийн дүр зураг их хэцүү байдалд оржээ. “Бид дэлхийд ганцаараа монгол гэртэй, ганцхан нүүдлийн соёлтой”, эсвэл “би малчны хүүхэд” гэж зарим улс төрчид өөрсдийгөө гадаадын орнуудад сурталчилж, хоосон бахархахын оронд, харин монгол гэр нь монголчуудын өнгөрсөн түүхэндээ бий болгосон гайхамшигт цогц зүйл ба дотроо олон гүн ухааныг агуулсан маш төгс тогтолдор зүйл гэдгийг ойлгож, энэ талаас нь ярьж танилцуулах нь зүйтэй хэмээн миний бие бодож байна. Өнөөдөр даяаршлын эрин үед дэлхийн улс орнууд өөрийн түүх, соёлын үнэт ов, тэдний онцлогийг хадгалж үлдэхийн төлөө бүхий л арга хэмжээг авч байна. Монгол Улс ч гэсэн үүнтэй хөл зэрэгцэн монгол

гэрээ, Төв Азийн бусад эсгий гэрийн түүхэн уламжлалтай улс, орноос илүү их онцгойлох ёстой. Миний бодлоор монгол гэрийн түүхэн утга, ач холбогдол, түүнтэй холбоотой гүн ухааны ойлголт, бэлгэдэл мөн ёс заншил нь хичнээн гадны болон дотоодын олон хүнд танигдаж, ил тод байх тусам, түүний онцлог нь бусад эсгий туургатнууд, тэдний өвөөс ялгарч харагдах болно. Энэ хирээрээ монгол гэрийн талаарх сөрөг ойлголтыг олон монголчуудын дунд залруулж, түүний ач холбогдлыг жинхэнэ утгаар нь үнэлэхэд сайнаар нөлөөлөх болно.

Abstract: Until the beginning of the 20th century almost all Mongols lived in *gers*. The industrializing process of the 1930s as well as progressive urbanization beginning in the 1950s, forced many thousands of Mongolians to move into modern houses or flats. After the transition from a Socialist regime to democracy in the 1990s Mongolians experienced drastic social changes. Nevertheless, the *ger* still remains the base of Mongolian culture. Because of natural disasters or economic reasons thousands of people moved to urban areas (especially Ulaanbaatar) from the countryside since the end of the 1990s. This caused a great expansion of the “*ger* districts” in the cities. The increasing air and soil pollution in Ulaanbaatar in recent years is widely perceived as a result of *ger* district expansion. In connection to this negative image the *ger* is currently more in the center of discussion. However, the Mongolian *ger* is an essential part of the nomadic cultural heritage, and concerns crucial customs and traditions such as the way of entering the *ger*, behaving there, dining etiquette etc. The Mongolian traditional way of counting time by observing how the sunlight falls into the *ger*, educating and instilling in children a sense of respect etc. are deeply connected to traditional cultural heritage. Today, as Mongolian society is globalizing, many of these historically important traditions and customs are forgotten and lost.

Ном зүй

1. Altangerel, Ganchimeg 2018, „Viehzüchterinnen – die neue Rolle der ländlichen Frauen“. In: Altangerel, Ganchimeg und Udo Barkmann (Eds): „Familie und Transformationsprozesse in der Mongolei“. BRD: 1-20 (in Print).
2. Ганчимэг Алтангэрэлийн 2017: Монголчуудын уламжлалт нүүдлийн соёл, ахуй даяршлын эрин үед: Өнөөгийн малчдад тулгамдаж буй асуудлууд (*Keeping the Traditional Nomadic Lifestyle: Challenges Herders Face in Contemporary Mongolia*). In: Mongolia and Northeast Asian Studies Vol. 2/ 2017, Association for the History and Culture of the Mongols, Japan: Fukyosha Publishing: 26-34.
3. Altangerel, Ganchimeg 2015: Der Sinn meines Lebens ist die Zukunft meiner Kinder“: Zur Lebenssituation alleinstehender Mütter in der gegenwärtigen Mongolei. Diss. Ulaanbaatar: Monsudar.

4. Altangerel, Ganchimeg 2014: „Mediendebatte über den Erhalt des materiellen und immateriellen Kulturerbes in der Mongolei“, 2014 оны 6 сарын 14-д Берлин хотод болсон „Kunst, Identität, Erkenntnis – Visionen und Konzepte für die Rolle von Kunst und Kulturpolitik für eine moderne Zivilgesellschaft in der Mongolei & die Außenkulturpolitik in Zusammenarbeit mit Deutschland“ олон улсын симпозиум дээр тавьсан илтгэл (хэвлэгдээгүй).
5. Б.Баатархүү; Д.Одсүрэн 2016: Монгол гэр тайлбар толь. (Encyclopedia of Ger: The Dwelling House of Mongols). Улаанбаатар: Тэпэ.
6. Bruun, Ole und Li Narangoa 2006: An New Moment in Mongol History: The Rise of the Cosmopolitan City. In: Bruun Ole and Li Narangoa (Eds): Mongols from Country to City: Floating Boundaries, Pastoralism and City Life in the Mongol Lands. Nordic Institute of Asian Studies Copenhagen: 1-20.
7. Bulag, Uradyn E. 1998: Nationalism and Hybridity in Mongolia. Oxford: Clarendon Press.
8. Eriksen, Thomas H. 2001: Between universalism and relativism: A critique of the UNESCO concepts of culture. In: Cowan, J.; M.-B. Dembour; R. Wilson (Hg.): Culture and Rights: Anthropological Perspectives. Cambridge University Press: 127-148.
9. Lixinski, Lucas 2013: Intangible Cultural Heritage in International Law. Oxford University Press.
10. Д.Майдар, Л.Дарьсүрэн 1976: Гэр: Орон сууцны түүхэн тойм. Улаанбаатар: Улсын хэвлэлийн газар.
11. Marsh, Peter K. 2006: Beyond the Soviet Houses of Culture: Rural Responses to Urban Cultural Policies in Contemporary Mongolia. In: Bruun Ole and Li Narangoa (Eds): Mongols from Country to City: Floating Boundaries, Pastoralism and City Life in the Mongol Lands. Nordic Institute of Asian Studies Copenhagen: 290-304.
12. National Statistics Office of Mongolia 2018: Mongolian Statistical Information Service, <http://www.1212.mn/> (last accessed 8 April 2018).
13. National Statistics Office of Mongolia 2011: Хүн ам, орон сууцны 2010 оны улсын тооллогын үр дүн. Улаанбаатар.
14. Нийслэлийн Статистикийн Газар 2018: Улаанбаатар хотын хүн ам.
15. Pegg, Carole 2001: Mongolian Music, Dance and Oral Narrative. Seattle and London: University of Washington Press.
16. Б.Ринчэн 1979: Монгол Ард Улсын угсаатны судлал, хэлний шинжлэлийн атлас. Улаанбаатар: Улсын хэвлэлийн газар.
17. Schaller, Peter 2015: Luftverschmutzung in Ulan Bator – ein ungelöstes Problem. In: Mongolische Notizen: Mitteilungen der Deutsch-Mongolischen Gesellschaft e.V. Nr. 23/ 2015, Bonn: 35-50.
18. Sneath, David 2006: The Rural and the Urban in Pastoral Mongolia. In: Bruun Ole and Li Narangoa (Eds): Mongols from Country to City: Floating Boundaries,

- Pastoralism and City Life in the Mongol Lands. Nordic Institute of Asian Studies Copenhagen: 140-161.
19. Schukowskaja N.A, 1996: Kategorien und Symbolik in der traditionellen Kultur der Mongolen. Berlin: Reinhold Schletzer Verlag.
 20. Taraschewski, Thomas 2008: Stadtentwicklung von Ulaanbaatar im Zeitalter fragmentierter Entwicklung. Berlin: Wissenschaftlicher Verlag.
 21. Humphrey, Caroline 1974: Inside a Mongolian Tent. New Society.
 22. Humphrey, Caroline; David Sneath 1999: The End of Nomadism? Society, State and Environment in Inner Asia. Durham: Duke University Press.
 23. Д.Чулуунбат 2013: Хан Хэнтийн тожил хийц. Улаанбаатар: Эзэн сүлд.
 24. Center of Cultural Heritage 2012: Cultural Heritage News and Information. Nr. 6, Ulaanbaatar.
 25. Г.Цэрэнханд 2015: Монголчуудын ураг төрөл, ёс заншил, зан үйл. Улаанбаатар: Адмон принт.
 26. Yundenbat, S. 2011: Important Intangible Cultural Heritage of the Mongols. Ulaanbaatar: Munkhiin Useg.